



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/456

Булган сум

Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих  
орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөө батлах тухай” А/236, А/189, А/80 дугаар хамтарсан тушаалын Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөний 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Зөвлөлийн дарга:

Ж.Ганболд (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Зөвлөлийн нарийн бичгийн дарга:

Б.Бат-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)

Зөвлөлийн гишүүд:

А.Оюунжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)

Б.Сэрчмаа (Боловсрол, шинжлэх ухааны газрын хяналтын Улсын байцаагч)

Б.Энхтуяа (Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн)

Б.Лхаелхам (Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн)

Л.Мөнхзул (Эрүүл мэндийн газрын Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн)

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ